

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhs@audit.gov.mn

Ихэрмерөн-Аудит ХХК-ийн захирал, аудитор Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг:
b_myadagmaaa@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/118
танай _____-ны № _____-т

ИХ-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭДАВАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 45,721.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг оруулдаг. Сургуулийн захирал Их-Уул сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөж, 94.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,875,049.77	233,238,259.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	45,721,577.00
3121	Төгрөг	00.00	45,721,577.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	45,721,577.00
35	БАРАА МАТЕРИАЛ	145,875,049.77	187,516,682.77
351	Түүхий эд материал	3,600,020.00	3,600,020.00
35130	Эм боох материал	3,600,020.00	3,600,020.00
354	Хангамжийн материал	126,980,029.77	168,621,662.77
35410	Бичиг хэргийн материал	3,137,740.00	4,069,740.00
35420	Аж ахуйн материал	4,360,700.00	8,679,950.00
35440	Түлш, шатах тослох материал	6,000,000.00	9,630,000.00
35460	Хүнсний материал	9,560,800.00	39,318,820.00
35470	Бусад хангамжийн материал	103,920,789.77	106,923,152.77
35600	Мал амьтад	15,295,000.00	15,295,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	871,009,618.26	889,190,264.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	871,009,618.26	889,190,264.56
392	Биет хөрөнгө	804,458,784.97	823,673,431.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	780,790,603.00	780,790,603.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-208,535,807.17	-252,021,042.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,588,994.06	417,183,845.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-188,389,757.12	-217,810,381.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	149,618,122.07	149,618,122.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,977,735.41	-83,744,858.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,905,000.00	8,905,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,262,416.50	-6,112,916.50
39217	Ном	22,721,782.04	26,865,060.04
393	Биет бус хөрөнгө	66,550,833.29	65,516,833.25
39301	Програм хангамж	6,325,000.00	6,325,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,120,166.71	-2,154,166.75
39303	Бусад биет бус хөрөнгө	61,346,000.00	61,346,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,016,884,668.03	1,122,428,524.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,016,884,668.03	1,122,428,524.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,016,884,668.03	1,122,428,524.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	723,665,838.00	723,665,838.00
51101	Өмч: - төрийн	723,665,838.00	723,665,838.00
512	Хуримтлагдсан үр дүн	-257,313,765.10	-151,769,908.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-257,313,765.10	-257,313,765.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	105,543,856.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	550,532,595.13	550,532,595.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,016,884,668.03	1,122,428,524.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,754,253,985.25	2,107,474,692.40
120	Нийтлэг татварын бус орлого	127,626,455.61	43,005,592.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,626,455.61	43,005,592.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,609,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	38,396,592.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,342,529.64	2,064,469,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,762,871,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	225,441,200.00	301,597,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,679,625,835.60	2,001,930,836.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,679,625,835.60	2,001,930,836.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,584,078,096.19	1,873,857,004.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,035,229,718.00	1,212,259,392.00
210101	Үндсэн цалин	637,607,616.00	1,091,685,363.00
210102	Нэмэгдэл	326,906,723.00	83,085,587.00
210104	Урамшуулал	70,715,379.00	37,488,442.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,400,921.23	152,797,015.00
210201	Тэтгэврийн даатгал	95,531,099.00	104,608,228.75
210202	Тэтгэмжийн даатгал	10,240,522.00	12,219,194.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,187,592.23	9,701,435.78
210204	Ажилгүйдлийн даатгал	2,040,219.00	2,388,030.65
210205	Эрүүл мэндийн даатгал	20,401,489.00	23,880,125.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,702,854.00	218,309,528.00
210301	Гэрэл, цахилгаан	4,587,002.00	8,922,587.00
210302	Түлш, халаалт	208,919,100.00	205,430,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,196,752.00	3,956,341.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,771,453.00	32,800,235.00
210401	Бичиг хэрэг	1,460,350.00	14,260,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,877,400.00	11,843,385.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	516,977.00	280,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,534,726.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,188,500.00	6,356,450.00
2105	Нормативт зардал	70,135,935.00	119,913,320.00
210502	Хоол, хүнс	69,604,435.00	119,913,320.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,000.00	9,619,200.00
210604	Урсгал засвар	127,000.00	9,619,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,241,600.00	28,932,631.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,233,600.00	16,964,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	10,959,931.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,974,614.96	99,225,683.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,668,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,526,324.96	91,557,483.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,547,739.41	128,073,832.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,325,000.00	121,598,560.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,010,500.00	91,186,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	314,500.00	30,411,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,360,246.00	6,475,272.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	74,628,149.65	105,543,856.30
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,597,576.32	105,543,856.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,626,627,529.64	2,069,078,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	4,609,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	4,609,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	4,609,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	4,609,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,626,627,529.64	2,064,469,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,762,871,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,762,871,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	225,441,200.00	301,597,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	225,441,200.00	301,597,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,592,929,929.64	1,948,082,123.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,592,929,929.64	1,948,082,123.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,497,382,190.23	1,802,916,651.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,034,946,132.00	1,213,348,468.00
210101	Үндсэн цалин	637,324,030.00	890,231,623.00
210102	Нэмэгдэл	326,906,723.00	272,878,998.00
210104	Урамшуулал	70,715,379.00	50,237,847.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,400,921.23	151,707,939.00
210201	Тэтгэврийн даатгал	95,531,099.00	103,559,868.70
210202	Тэтгэмжийн даатгал	10,240,522.00	12,183,507.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,187,592.23	9,696,405.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,040,219.00	2,388,031.05
210205	Эрүүл мэндийн даатгал	20,401,489.00	23,880,125.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	219,215,354.00	227,809,528.00
210301	Гэрэл, цахилгаан	4,587,002.00	8,922,587.00
210302	Түлш, халаалт	211,431,600.00	214,930,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,196,752.00	3,956,341.00
2105	Нормативт зардал	66,486,400.00	132,579,700.00
210502	Хоол, хүнс	63,325,800.00	132,579,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,865,600.00	8,700,000.00
210604	Урсгал засвар	4,865,600.00	8,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,241,600.00	15,680,531.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,233,600.00	4,570,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	11,109,931.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,818,976.36	53,090,485.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	35,545,385.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,818,976.36	17,545,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	95,547,739.41	145,165,472.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,325,000.00	138,690,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,010,500.00	108,278,600.00
		314,500.00	30,411,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,360,246.00	6,475,272.00
		1,360,246.00	6,475,272.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,697,600.00	120,995,977.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,697,600.00	75,274,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,697,600.00	75,274,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,697,600.00	75,274,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,697,600.00	75,274,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
		-33,697,600.00	-75,274,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
		00.00	45,721,577.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
		00.00	45,721,577.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	569,644,364.81	-234,537,264.95	1,058,772,937.86
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,665,838.00	569,644,364.81	-234,537,264.95	1,058,772,937.86
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,420,249.59	-57,420,249.59
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	550,532,595.13	-257,313,765.10	1,016,884,668.03
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	550,532,595.13	-257,313,765.10	1,016,884,668.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,665,838.00	550,532,595.13	-257,313,765.10	1,016,884,668.03
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	105,543,856.30	105,543,856.30
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	550,532,595.13	-151,769,908.80	1,122,428,524.33

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,767,442,400.00	1,721,759,223.00	45,683,177.00	97.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,767,442,400.00	1,721,759,223.00	45,683,177.00	97.4
210	Бараа, үйлчилгээний зардал	1,628,752,200.00	1,583,069,023.00	45,683,177.00	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,201,018,100.00	1,161,248,468.00	39,769,632.00	96.7
210101	Үндсэн цалин	898,606,900.00	839,744,354.00	58,862,546.00	93.4
210102	Нэмэгдэл	259,056,900.00	271,266,267.00	(12,209,367.00)	104.7
210104	Урамшуулал	43,354,300.00	50,237,847.00	(6,883,547.00)	115.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,127,300.00	145,195,439.00	4,931,861.00	96.7
210201	Тэтгэврийн даатгал	102,086,500.00	99,131,368.70	2,955,131.30	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	12,010,200.00	11,662,507.83	347,692.17	97.1
210203	ҮОМШӨ ний даатгал	9,608,200.00	9,279,605.68	328,594.32	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,402,000.00	2,283,831.05	118,168.95	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	24,020,400.00	22,838,125.74	1,182,274.26	95.1
2105	Нормативт зардал	132,579,700.00	132,579,700.00	-	100.0
210502	Хоол, хүнс	132,579,700.00	132,579,700.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	16,267,400.00	15,680,531.00	586,869.00	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,570,600.00	4,570,600.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	11,696,800.00	11,109,931.00	586,869.00	95.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	128,759,700.00	128,364,885.00	394,815.00	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,214,600.00	110,819,785.00	394,815.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,545,100.00	17,545,100.00	-	100.0
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,690,200.00	138,690,200.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,690,200.00	138,690,200.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	108,278,600.00	108,278,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	30,411,600.00	30,411,600.00	-	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,767,442,400.00	1,767,480,800.00	(38,400.00)	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,762,871,800.00	1,762,871,800.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,762,871,800.00	1,762,871,800.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,570,600.00	4,609,000.00	(38,400.00)	100.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,570,600.00	4,609,000.00	(38,400.00)	100.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	45,721,577.00	(45,721,577.00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	82.00	82.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	54.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	-	100.0

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
210	Бараа, үйлчилгээний зардал	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,100,000.00	52,100,000.00	-	100.00
210101	Үндсэн цалин	52,100,000.00	50,487,269.00	1,612,731.00	96.90
210102	Нэмэгдэл	-	1,612,731.00	(1,612,731.00)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,430,200.00	6,512,500.00	1,917,700.00	77.25
210201	Тэтгэврийн даатгал	6,346,200.00	4,428,500.00	1,917,700.00	69.78
210202	Тэтгэмжийн даатгал	521,000.00	521,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	416,800.00	416,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	104,200.00	104,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,042,000.00	1,042,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,367,100.00	227,809,528.00	4,557,572.00	98.04
210301	Гэрэл цахилгаан	10,000,000.00	8,922,587.00	1,077,413.00	89.23
210302	Түлш, халаалт	218,467,100.00	214,930,600.00	3,536,500.00	98.38
210303	Цэвэр, бохир ус	3,900,000.00	3,956,341.00	(56,341.00)	101.44
2106	Эд хогшил худалдан авах	8,700,000.00	8,700,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,700,000.00	8,700,000.00	-	100.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
132001	Орон нутгийн төсвөөс	301,597,300.00	295,122,028.00	6,475,272.00	97.85
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	82.00	82.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	54.00	54.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Их-Уул сумын ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Багш бүр сургалтын чанарыг бодитой үнэлэх арга зүйд суралцан, сурлагын хоцрогдлыг бууруулж сурагчдыг адил тэгш суралцах боломжоор хангана.” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Их-Уул сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөж, 94.0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
 - БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
 - БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
 - БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
 - БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
 - БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу сургуулийн захирлын 2022 оны А/03 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,543.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	45,721.6	45,721.6
Бараа материал	145,875.0	187,516.7	41,641.7
Үндсэн хөрөнгө	871,009.6	889,190.2	18,180.6
Нийт хөрөнгө	1,016,884.6	1,122,428.5	105,543.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,016,884.6	1,122,428.5	105,543.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,016,884.6	1,122,428.5	105,543.9

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмч өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 45,721.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 41,641.7 мянган төгрөгөөр өссөн нь түлээ, хүнсний материалын нөөц нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 18,180.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 109,738.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 91,557.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Эздийн өмч данс нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 105,543.9 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,958,382.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 392,781.0 мянган төгрөгөөр бууруулан 1,565,601.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой, төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн А/170 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 201,841.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 1,767,442.4 мянган төгрөгөөр, үүнээс 1,762,871.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 4,570.6 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 389,350.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Их-Уул сумын ЗДТГ-т хүргүүлснийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 15 -ны өдрийн 06 дугаар тогтоолоор 389,350.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлаар нэмэгдүүлэн баталсантай холбоотой.

Их-Уул сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж 53,601.1 мянган төгрөгөөр бууруулан, 335,749.3 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 1,762,871.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 301,597.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 2,064,469.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 4,570.6 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,570.6 мянган төгрөгийн төвлөрүүлж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 97.9 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 6,475.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 100 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 45,721.6 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	4,678.7	4,678.7	-	100.0
2	80312-Сургалт семинар	2,339.4	2,339.4	-	100.0
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	5,380.5	5,363.6	16.9	99.7
4	81801-Үдийн цай хөтөлбөр	108,278.6	108,278.6	-	100.0
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	59,940.0	59,940.0	-	100.0
6	81806-Дотуур байр	203,661.1	199,838.8	3,822.3	98.1
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	10,527.1	10,527.1	-	100.0
8	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,183,557.6	1,146,155.8	37,401.8	96.8
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	184,508.8	180,066.6	4,442.2	97.6
10	81848- Сурах бичгийн түрээс	4,609.0	4,570.6	-	100.0
Дүн		1,767,480.8	1,721,759.2	45,721.6	99.2
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	241,067.1	236,509.5	4,557.6	98.1
2	80112-Нийтлэг үйлчилгээ	60,530.2	58,612.5	1,917.7	96.8
Дүн		301,597.3	295,122.0	6,475.3	97.4
Нийт дүн		2,069,039.7	2,016,581.2	52,196.9	98.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Б.Мядагмаа гүйцэтгэж, анхан шатын хяналтыг аудитор Ц.Мөнхтуяа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх,

аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,680,585.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 33,611.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба улсын төсвийн мэдээлэл технологийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас 45,721.6 мянган төгрөг хэмнэж дансны үлдэгдлээр үлдсэн, орон нутгийн төсвөөс гэрэл цахилгаан, урсгал засварын зардлаас 6,475.3 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 145 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	2	-	2	-	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Харилцах дансны үлдэгдлийн 45,721.6 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 99,889.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 99,889.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Үнэ төлбөргүй ирсэн түрээсийн сурах бичиг, БШУЯ-аас ирсэн шарах шүүгээг үндсэн хөрөнгөд орлого аваагүйг дансанд бүртгэж залруулсан.
- Үр дүнгийн тайланд үдийн хоолны зардлыг дотуур байрны хүүхдийн хоолны зардлаар бүртгэснийг залруулан бүртгэсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй ирсэн түрээсийн сурах бичиг, БШУЯ-аас ирсэн шарах шүүгээг үндсэн хөрөнгөд орлого аваагүйг дансанд бүртгэж залруулсан.	1	8,702.1			1	8,702.1	1	8,702.1				
Үр дүнгийн тайланд үдийн хоолны зардлыг дотуур байрны хүүхдийн хоолны зардлаар бүртгэснийг залруулан бүртгэсэн.	1	91,187.0			1	91,187.0	1	91,187.0				
Дүн	2	99,889.1			2	99,889.1	2	99,889.1				